Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/92/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Манаргүл<br>Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........................................................**Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................4
3. Аудитын тайлан........................................................12
   3.1 Ерөнхий зүйл........................................................12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................12
   3.4 Материаллаг байдал ........................................................13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................................13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................................15
   3.8 Аудитын гол асуудал ........................................................15
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................16
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................................16
4. Аудитын илрүүлэлт ........................................................16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Төсвийн захирагч

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА С.БЕРДИГУЛ ТАНАА

2022.04.23 № 121

танай ____________ -ны № ____________ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,951,922.00** | **64,212,965.08** |
| **33** | **АВЛАГА** | - | 33,466,504.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 44,504.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 33,422,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 18,951,922.00 | 30,746,461.08 |
| **351** | **Түүхий эд материал** | 9,694,954.00 | 15,443,778.04 |
| 35130 | Эм боох материал | 9,694,954.00 | 15,443,778.04 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,256,968.00 | 15,302,683.04 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,203,458.00 | 12,389,193.04 |
| 35460 | Хүнсний материал | 53,510.00 | 2,913,490.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **553,440,604.85** | **609,409,582.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 553,440,604.85 | 609,409,582.05 |
| **392** | **Биет хөрөнгө** | 550,076,604.85 | 606,105,582.05 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 492,369,200.00 | 492,369,200.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (21,823,611.96) | (29,901,343.80) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 98,032,665.00 | 79,000,522.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (62,830,796.52) | (50,844,652.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 78,974,845.12 | 151,215,340.13 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (47,984,689.70) | (63,067,730.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,531,599.92 | 51,227,683.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (35,167,607.01) | (36,218,437.17) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,500,000.00 | 24,500,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,525,000.00) | (12,175,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,364,000.00 | 3,304,000.00 |
| 39301 | Програм хангамж | 850,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (630,000.00) | (690,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,144,000.00 | 3,144,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **572,392,526.85** | **673,622,547.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,354,629.00** | **4,108,800.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,354,629.00 | 4,108,800.00 |
| **413** | **Өглөг** | 3,354,629.00 | 4,108,800.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,527,429.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 1,827,200.00 | 4,108,800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,827,200.00 | 4,108,800.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **569,037,897.85** | **669,513,747.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 569,037,897.85 | 669,513,747.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 228,845,545.08 | 228,845,545.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 228,845,545.08 | 228,845,545.08 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 32,664,811.05 | 133,140,660.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 32,664,811.05 | 32,664,811.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 100,475,849.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 307,527,541.72 | 307,527,541.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **572,392,526.85** | **673,622,547.13** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **535,642,558.00** | **796,592,886.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,998,200.00** | **34,611,568.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,998,200.00 | 34,611,568.04 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 6,998,200.00 | 34,611,568.04 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,998,200.00 | 34,611,568.04 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **528,644,358.00** | **761,981,318.01** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 406,494,100.00 | 561,298,895.01 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 82,163,995.01 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 406,494,100.00 | 479,134,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 31,927,233.00 | 118,844,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,565,700.00 | 51,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,877,363.00 | 117,137,831.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,484,170.00 | 1,655,882.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 55,032,395.00 | 16,721,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,362,400.00 | 16,721,100.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 30,669,995.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,190,630.00 | 65,116,610.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,190,630.00 | 65,116,610.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **512,819,474.15** | **696,091,134.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **512,819,474.15** | **696,091,134.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 509,290,495.15 | 658,491,134.57 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 349,900,993.02 | 426,140,079.00 |
| 210101 | Үндсэн цалин | 233,632,293.02 | 261,876,579.00 |
| 210102 | Нэмэгдэл | 93,308,700.00 | 102,822,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,804,000.00 |
| 210104 | Урамшуулал | 22,960,000.00 | 54,637,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,304,300.00 | 51,394,645.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,599,400.00 | 36,474,145.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,426,100.00 | 3,730,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,741,000.00 | 2,984,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 685,300.00 | 746,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,852,500.00 | 7,460,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,142,180.00 | 16,245,925.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,774,880.00 | 1,657,625.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,179,800.00 | 14,588,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 187,500.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,069,970.00 | 42,585,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,222,450.00 | 2,845,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,820,650.00 | 29,222,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 866,900.00 | 2,320,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 627,500.00 | 1,375,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 5,456,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,532,470.00 | 1,365,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,378,116.00 | 81,898,738.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,901,426.00 | 70,580,118.96 |
| 210502 | Хоол, хүнс | 6,076,690.00 | 8,297,520.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 400,000.00 | 3,021,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,312,300.00 | 1,088,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 170,000.00 | 356,940.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,142,300.00 | 732,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,060,000.00 | 2,384,831.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,060,000.00 | 2,384,831.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 321,920.00 | 601,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 237,900.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 35,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,580.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 38,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,440.00 | 42,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 6,000.00 | 77,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,800,716.13 | 36,150,375.61 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,004,000.00 | 2,194,260.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,796,716.13 | 33,956,115.61 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,528,979.00 | 37,600,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 37,600,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 37,600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,163,059.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,163,059.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 365,920.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 365,920.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **22,823,083.85** | **100,501,751.48** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 25,902.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 25,902.20 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (25,902.20) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **22,823,083.85** | **100,475,849.28** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **32,664,811.05** | **569,037,897.85** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **32,664,811.05** | **569,037,897.85** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **32,664,811.05** | **569,037,897.85** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 100,475,849.28 | 100,475,849.28 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **133,140,660.33** | **669,513,747.13** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **497,974,363.00** | **646,395,323.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **497,974,363.00** | **646,395,323.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 406,494,100.00 | 479,134,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 406,494,100.00 | 479,134,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 31,927,233.00 | 118,844,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,565,700.00 | 51,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,877,363.00 | 117,137,831.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,484,170.00 | 1,655,882.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,362,400.00 | 16,721,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,362,400.00 | 16,721,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,190,630.00 | 31,694,610.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,190,630.00 | 31,694,610.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **497,555,863.00** | **638,608,323.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **497,555,863.00** | **638,608,323.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **494,026,884.00** | **601,008,323.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 348,941,400.00 | 427,712,012.00 |
| 210101 | Үндсэн цалин | 232,672,700.00 | 263,448,512.00 |
| 210102 | Нэмэгдэл | 93,308,700.00 | 102,822,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 6,804,000.00 |
| 210104 | Урамшуулал | 22,960,000.00 | 54,637,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,304,300.00 | 51,394,645.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,599,400.00 | 36,474,145.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,426,100.00 | 3,730,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,741,000.00 | 2,984,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 685,300.00 | 746,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,852,500.00 | 7,460,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,854,180.00 | 16,245,925.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,774,880.00 | 1,657,625.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,891,800.00 | 14,588,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 187,500.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,599,000.00 | 37,340,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,222,450.00 | 2,845,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,882,150.00 | 25,113,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 866,900.00 | 2,320,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 627,500.00 | 1,445,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 5,615,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,546,984.00 | 61,644,410.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,768,984.00 | 47,375,810.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,378,000.00 | 11,157,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 400,000.00 | 3,111,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,312,300.00 | 1,374,940.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 170,000.00 | 642,940.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,142,300.00 | 732,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,060,000.00 | 2,384,831.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,060,000.00 | 2,384,831.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 321,920.00 | 601,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 237,900.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 35,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,580.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 38,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,440.00 | 42,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 6,000.00 | 77,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,086,800.00 | 2,309,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,086,800.00 | 2,309,260.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,528,979.00** | **37,600,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 37,600,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 37,600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,163,059.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,163,059.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 365,920.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 365,920.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **418,500.00** | **7,787,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **418,500.00** | **7,787,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **418,500.00** | **7,787,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 418,500.00 | 7,787,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 418,500.00 | 7,787,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(418,500.00)** | **(7,787,000.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 528,110,300.00 | 527,550,610.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 528,110,300.00 | 527,550,610.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 528,110,300.00 | 527,550,610.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 373,012,200.00 | 373,012,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 230,183,300.00 | 230,183,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 102,822,300.00 | 102,822,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,804,000.00 | 6,804,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,202,600.00 | 33,202,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,356,600.00 | 50,356,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,436,100.00 | 35,436,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,730,100.00 | 3,730,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,984,100.00 | 2,984,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 746,000.00 | 746,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,460,300.00 | 7,460,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,989,100.00 | 15,989,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,400,800.00 | 1,400,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,588,300.00 | 14,588,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,976,900.00 | 29,976,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,453,500.00 | 2,453,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,791,900.00 | 18,791,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,220,700.00 | 2,220,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,445,200.00 | 1,445,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,065,600.00 | 5,065,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,472,600.00 | 45,912,910.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,624,000.00 | 33,064,310.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,857,500.00 | 9,857,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,991,100.00 | 2,991,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,678,500.00 | 7,678,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,946,500.00 | 6,946,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 732,000.00 | 732,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 510,000.00 | 510,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 510,000.00 | 510,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 601,700.00 | 601,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 35,600.00 | 35,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 48,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,000.00 | 38,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 42,300.00 | 42,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,500.00 | 77,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,512,700.00 | 3,512,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,512,700.00 | 3,512,700.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 528,110,300.00 | 527,550,610.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 479,134,900.00 | 479,134,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 479,134,900.00 | 479,134,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 16,721,100.00 | 16,721,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 16,721,100.00 | 16,721,100.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,254,300.00 | 31,694,610.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 32,254,300.00 | 31,694,610.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 31.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6.00 | 9.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | - | 10,052.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 473.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаторoор эмчлүүлэгсдийн тоо | | 9,579.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.00** | **31.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 20.00 | 25.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 6.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,927,233.00** | **118,844,713.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,927,233.00** | **118,844,713.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 31,927,233.00 | 81,244,713.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,916,400.00 | 54,699,812.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,916,400.00 | 33,265,212.00 |
| 210104 | Урамшуулал | - | 21,434,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,000.00 | 1,038,045.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,000.00 | 1,038,045.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 256,825.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 256,825.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,073,470.00 | 7,363,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 392,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,073,470.00 | 6,321,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 100,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 550,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,017,363.00 | 15,731,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 20,517,363.00 | 14,311,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 500,000.00 | 1,300,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 120,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 360,000.00 | 1,874,831.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 360,000.00 | 1,874,831.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,510,000.00 | 280,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,510,000.00 | 280,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 37,600,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 37,600,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 37,600,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 31,927,233.00 | 118,844,713.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 31,927,233.00 | 118,844,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,565,700.00 | 51,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,877,363.00 | 117,137,831.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,484,170.00 | 1,655,882.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн зорилго нь: Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, чанартай, хүртээмжтэй, чирэгдэл хүлээгдэлгүй үр дүнтэй үзүүлэх

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

- Хамт олны оролцоог хангах
- Үйлчлүүлэгчдийг дээдлэх
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах
- Ил тод нээлттэй байх
- Шинэ санаа санаачилгыг дэмжих

Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулж шалгалт хийсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 512,8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10,3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101,2 сая төгрөгөөр буюу 17,7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 33,466.5 | 33,466.5 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 18,951.9 | 30,746.5 | 11,794.5 |
| Үндсэн хөрөнгө | 553,440.6 | 609,409.6 | 55,969.0 |
| **Нийт хөрөнгө** | **572,392.5** | **673,622.5** | **101,230.0** |
| Өр төлбөр | 3,354.6 | 4,108.8 | 754.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 569,037.9 | 669,513.7 | 100,475.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **572,392.5** | **673,622.5** | **101,230.0** |

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 33,5 сая төгрөг болж өссөн нь Ковид 19 цар тахалын улаан бүсд ажилласан урамшуулал хөлсийн мөнгө болох эрүүл мэндийн даатгалын сангаас авах 33,4 сая төгрөгийн, ажиллагсадтай холбоотой зардлын авлага 0,1 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,7 сая төгрөг болж 11,8 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 102,1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл

мэндийн газраас 14,4 сая төгрөгийн хамгаалах болон эм, эмнэлгийн хэрэгсэл, 3,9 сая төгрөгийн багийн эмч нарын багц бусад аж ахуйн материал, сумын ОНХСангаас 16,0 сая төгрөгийн Ковид-19 цар тахал өвчинөөс хамгаалх эмнэлгийн хэрэгсэл, эргэлийн эмийн сангаас 0,3 сая төгрөгийн эм бүгд 136,8 сая төгрөгийн бараа материалыг орлого авч, 123,3 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, 0,3 сая төгрөгийн эм, 1,4 сая төгрөгийн бүгд 1,7 сая төгрөгийг бараа материалын байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 35, 38 дугаар тушаалаар акталж зохих журмын дагуу устгалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө 101,2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ЭМЯамнаас 52,1 сая төгрөгийн шүдний кабинетийн тоног төхөөрөмж, сумын ОНХСангаас эмнэлгийн бохирын цоног гаргахад 5,0 сая төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлж авсан 25,1 сая төгрөгийн, нийт 89,9 сая төгрөгийн орлого авч, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 76 тоот тогтоолоор 19,0 сая төгрөгийн авто тээврийг аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дансад шилжүүлсэн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 48 тоот тогтоолоор 1,0 сая төгрөгийн тавилга аж ахуйн эд хогшил акталсан, үндсэн хөрөнгөд 20,0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхний 3,3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст вакцинжуулалттай холбоотой гарсан тээвэр шатахууны үнэд 4,1 сая төгрөгийн өр шинээр үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 669,5 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 100,5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг 528,1 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 528,1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд 527,6 сая төгрөг зарцуулж 0,5 сая төгрөгийг хэмнэсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилтийн хэмжээгээр хэмнэлттэй ажилласан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 479.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16,7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 31.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зарлагын 80,3 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 19,7 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Эрүүл мэндийн яамны 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 4/153 дугаар албан бичгээр хөдөөгийн хүн амд эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, эмийн мэргэжилтний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бий болгох зорилгоор Эрүүл мэндийн яамны 2017 оны удирдлагын зөвлөлийн хурлаас “Эмийн эргэлтийн сан”-г сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлэх тухай зөвлөмжийн дагуу батлагдсан орон тоогүй мөртлөө сумын Эргэлтийн эмийн сангийн эрхлэгчийг эм зүйчийн цалингийн сүлжээгээр цалинжуулж ажиллуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 118,8 сая төгрөгийг нэмэлт дансаар хүлээн авснаас 1,6 сая төгрөгийг Эргэлтийн эмийн сангаас, 0,1 сая төгрөгийг Монголын эмч мэргэжилтнүүдийн холбооноос, аймгийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 , А/585 тоот тушаалуудаар Ковид-19-ын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулал, нэг удаагийн тэтгэмжид 37,6 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 цар тахлын өвчнөөр өвдсөн гэрээр болон хэвтэн эмчлүүлэгсэдийн шууд ба шууд бус зардлын санхүүжилтээс 79,5 сая төгрөгийг авсан байна.

Нэмэлт санхүүжилтээс зарцуулсан зардлыг задалж үзэхэд Ковид-19 цар тахлын үед ажилласан ажиллагсадын цалин, урамшилд 55,6 сая, түр эмнэлгийн гэрэл цахилгаан 0,2 сая төгрөг, бичиг хэрэгт 0,4 сая, тээвэр шатахуунд 6,3 сая, шуудан холбоо интернетийн мөнгөд 0,1 сая, БҮТЭЗ-ийн зардалд 0,5 сая, эм, эмнэлгийн хэрэгсэлд 14,3 сая, хоол хүнсэнд 1,3 сая, нормын хувцас 0,1 сая, дотоод албан томилолт 1,8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 0,3 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшалд 37,6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар Толбо сумын Эрүүл мэндийн төвийн аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй боловч Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллаагүй, 11,6 сая төгрөгийн орлогыг нотлох боломжгүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага өгч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитын тайланд тусгахаар болов.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 528,1 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 230,4 сая төгрөгийн 117 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2 мэдээллийг хугацаа хосроосон байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 32,0 сая төгрөгийн 3 гүйлгээ гарснаас 1 мэдээллийг хугацаанд, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Өр, авлага үүсгэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 95,1 хувьтай хэрэгжсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж аймгийн ЭМГ-ын үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

Толбо сумын ЭМТөвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Харин ЭЭСангийн санхүүгийн тайлангаас дараах алдаа зөрчил илэрч албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Нягтлан бодогчийн тооцоогоор Эргэлтийн эмийн сан нь 2021 онд нийт 11556.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн болович нотлох баримтууд нь хангалтгүй, санхүүгийн баримтуудыг үдэж цэгцлээгүй, задгай баримт ирүүлсэн нь аудитаар орлого, зарлагыг

тооцох боломжгүй, Эргэлтийн эмийн сангийн бүртгэл, тооцоо зохих журмаар явагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн *13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна",* 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан "Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Толбо сумын Эрүүл мэндийн төв | | | | | | | | | | |
| 2 | ЭЭСан | 1 | 11,5 | | | | | 1 | 11,5 | | |
| | **НИЙТ** | **1** | **11,5** | | | | | **1** | **11,5** | | |